**МОНГОЛ УЛСЫН**
**ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН**
**ТУШААЛ**

2015 оны 09 сарын 21 өдөр Дугаар 239 Улаанбаатар хот

Зохион байгуулалтын
бүтцэд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан зохион байгуулалтын бүтцийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг боловсруулан, 2015 оны 10 дугаар сарын 5-ны дотор батлуулахыг Иргэний нисэхийн ерөнхий газар (Г.Нямдаваа)-т даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын “Иргэний нисэхийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцэд өөрчлөлт оруулах тухай” 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 13 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД М.ЗОРИГТ

Саднон дарга-Т
Заалтыг хэрэгжүүлэх
24/IX-15

081012

Зам, тээврийн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 21 -ны өдрийн 239 дугаар тушаалын хавсралт

УХА0115 5919487

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ

